



УИХ-ЫН ГИШҮҮН
Л.МӨНХБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ. ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226-3168. Факс: (976-11) 31-23-15,
E-mail: info@mrtt.gov.mn, http://www.mrtt.gov.mn

2018-06-06 № 81/2646
таний 2018-05-16-ны № 23-т

Г Г

Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр батлагдсантай холбогдуулан Таны 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 23 тоот албан бичгээр тавьсан асуулгад дараах хариуг хүргүүлж байна.

1. Уг хууль 2017 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлснээс хойш 2 сар хүрэхгүй хугацааны дараа хөвөлтийн улирал дууссан ч энэ хугацаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга наарт тус хуулиар үүрэг болгосон:

- нутаг дэвсгэртээ усан замын тээвэр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;
- усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон улсын мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран усан замын тээврийн хяналтыг хэрэгжүүлэх;
- орон нутгийн усан замын сүлжээнд усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх, аялах чиглэл, хөвөлтийн улирлын эхлэх, дуусах хугацаа, бүсийг усан замын тээврийн хэрэгслийн зориулалт, хүчин чадалд нийцүүлэн тухайн орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагатай хамтран батлах;
- тухайн орон нутгийн өмчийн усан замын дохио, тэмдэг болон зогсоолын засвар, арчлалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих;
- усан замын тээврийн хөвөлтийн улиралд ажиллах авран хамгаалах байнгын бус ажиллагаатай нэгжийг орон нутаг дахь хэрэгцээ шаардлагыг харгалзан нутаг дэвсгэртээ байгуулах;
- орон нутгийн онцгой байдлын газар болон усан замын тээврийн хэрэгслийн ахмад, өмчлөгч, зээмшигч, жолооч нартай хамтран ажиллах, хяналт тавих;
- усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, холбогдох төрийн байгууллага болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран усан замын тээврийн тухай хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилан таниулах зэрэг ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Мөн нуур гол, мөрөн бүхий аймгуудын Засаг дарга нарт болон татварын албадад хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг даалгасан албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн яамнаас хүргүүлж, нутгийн захирагааны байгууллагуудыг мэдээллээр хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсан.

Хуулийн хэрэгжилтийг хангах, усан замын тээврийн аюулгүй байдалд хяналт тавих ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Далайн захирага нь Онцгой байдлын ерөнхий газартай усан замын салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байгаа ба Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газраас томилсон аврах баг Хөвсгөл нуурт хяналт тавьж, аврах ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хуульд заасан захирагааны хэм хэмжээний актууд болох 3 дүрэм, 4 журмыг шинээр болон шинэчлэн боловсруулж эхлээд байгаа ба цаашид гарын авлага болгон хэвлүүлж олон нийтэд сурталчилах, хууль, дүрэм, журамд тусгагдсан асуудлаар 2018 оны 6 дугаар сард хэрэглэгчдэд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Хуулийг хэрэгжүүлэх явцад дараах хундрэл бэрхшээл гарч байна. Үүнд: Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад усан замын тээврийн хэрэгслийн даатгал, түүний дотор усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал тусгагдсан.

Усан замын тээврийн хэрэгслийн болон усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгалыг "даатгалын шинэ бүтээгдэхүүн" гэж Монголын Даатгагчдын холбоо үзэж байгаа ба уг асуудлаар даатгалын компаниуд олон улсын жишигийг судлан даатгалын төлбөрийн хэмжээг тогтоохоор судалгаа хийгээд тодорхой нэг үнэ тогтоож, түүнийг нь Монголын Даатгагчдын холбоо хянаж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж батлуулсны дараа "усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн даатгал" гэсэн даатгалын шинэ бүтээгдэхүүн бий болж, даатгалын компаниуд энэхүү шинэ бүтээгдэхүүнийг даатгах эрхтэй болох юм.

Энэ асуудлаар Монголын Даатгагчдын холбоо, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгал, Маркетингийн газартай удаа дараа албан бичиг тус яамнаас хүргүүлж, уулзалт ярилцлага зохион байгуулж санал солилцоход салбар салбарын хуульд тусгагдсан даатгалын заалтуудыг нэгтгэж Даатгалын ерөнхий хууль боловсруулах ажлын хэсэг байгуулахаар Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөлд ярилцаж шийдвэр гаргасан гэж мэдэгдээд байна.

Мөн хуульд заасан усан замын аюулгүй байдлыг хангахад зуны улиралд усан замын хяналтын эргүүл хийх, өвлүүн улиралд мөсөн замын тээвэр хийх зорчиход хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах хяналтын пост ажиллуулахад гарах шатах тосплох материал, цалин, хоол хүнс, хувцас хунаар, унаа, тусгай хэрэгслийн зардлыг шийдвэрлэх асуудал хундрэлтэй байна.

Түүнчлэн хуулиар усан замын хяналтад тухайн нуур, гол, мөрөн, цөөрмийг харьяалж буй орон нутгийн байгаль хамгаалагчдыг татан оролцуулахаар заасан бөгөөд тэдгээрийг сургалтад хамруулахаар төлөвлөж байгаа ба мөн зардлын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

2. Хөвөлтийн улирал эхэлж байгаатай холбогдуулан усан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор хуульд заасан "Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм", "Усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм"-ийг шинээр боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны

263 дугаар тушаалаар батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж улсын нэгдсэн бүртгэлийн 3861 дүгээрт бүртгүүлсэн бөгөөд цаашид "Усан замын тээврийн тухай" хуульд заасан дүрэм, журмуудыг шинээр буюу шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.

Хөвсгөл нуур болон бусад томоохон нуур, гол, мөрөнд усан замын тээврийн хэрэгслээр үйлчилгээ эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд "Төрийн хяналт шалгалтын тухай" хууль, "Усан замын тээврийн тухай" хууль болон тээврийн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батлагдсан дүрэм, журмын дагуу хяналт тавьж ажиллаж байгаагаас гадна "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" үндэсний сургалт семинарыг Хөвсгөл нуурт жил бүр зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 150 орчим усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчид, хуулийн этгээдийн удирдлага, менежерийг сургалтад хамруулж, усан замын тээврийн тухай хууль тогтоомжийг тухай бүр танилцуулж мэдээлэл хийж, сурталчилж ирлээ.

Мөн "Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын дагуу Хөвсгөл нуурт болон бусад нуур, гол, мөрөнд ашиглагдаж буй нийт 155 /2017 оны байдлаар/ усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийж, тоо бүртгэлд хамруулж, улсын дугаар олгов.

Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлийн ажиллагаа гол төлөв Хөвсгөл. Архангай аймгуудад хийгдэж байгаа тул баруун болон зүүн аймгуудын гол, мөрөн, нуурт ашиглагдаж буй усан замын тээврийн хэрэгслийг тоо бүртгэлд бүрэн хамруулах, цаашид нуур гол, мөрөн бүхий бүх аймгуудын усан замын тээврийн хэрэгслийг тоо бүртгэлд хамруулах ажлыг шат дараалан зохион байгуулна.

Мөн зуны улиралд аялал зугаалгын зорилгоор гол, мөрөн, нуурыг зорин ирж усан замын тээврийн хэрэгслээр үйлчлүүлж буй иргэдийн аюулгүй байдлыг хангах, усан орчинг бохирдуулахгүй байх, усны ослоос урьдчилан сэргийлэх талаарх анхааруулга, сээрэмжлүүлэг өгөх мэдээлэл, сурталчилгааны самбаруудыг зорчигч, аялагчдын урсгал, хөдөлгөөн ихтэй усан замын томоохон зогсоолууд болон автотээврийн хэрэгслийн шалган нэвтрүүлэх цэгт байрлуулахаар усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэд, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаад байна.

3. Зам, тээврийн хөгжлийн сайд аймгуудын Засаг дарга нартай жил бүр байгуулдаг гэрээнд усан болон мөсөн замын тээврийн аюулгүй байдлыг хангах асуудлыг тусган жилийн эцэст дүгнэн ажилладаг. Тухайлбал, 2018 онд байгуулсан гэрээнд Автотээврийн тухай хуулийн 7.1.6-д заасан "орон нутгийн цаг уурын байдлыг харгалzan мөсөн замын тээвэрлэлтийг эхлэх, дуусах хугацаа, чиглэл, мөсний даацыг тухайн орон нутгийн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагатай хамтран тогтоох" гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртэй зохион байгуулж, автотээврийн хэрэгслийн мөсөн замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх, мөсний хагарал /хил/ байнга гардаг /тохой, булан гэх мэт/ газруудад анхааруулах туг дарцаг хатгах, тусгай тэмдэг тэмдэглэгээ тавих ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, хяналтын цэгүүд буюу хяналтын байцаач ажиллуулах, эгзэгтэй цэгүүдэд урьд ёмне нь мөсөн замын тээврийн үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай нутгийн хүмүүсээс сонгож гэрээгээр ажиллуулах буюу байгаль хамгаалагчдыг татан оролцуулах, ийм тохиолдолд ажил гүйцэтгэхэд зарцуулах хөрөнгө мөнгийг шийдвэрлэж, ажиллаж буй хүмүүсийг унаа тэрэг, бусад шаардлагатай хэрэгслээр хангах зэрэг арга хэмжээг авч ажиллахаар тусган хэрэгжүүлж байна.

Цаашид хойд талын сумдын иргэд өвлийн улиралд байнга зорчих шаардлага гардаг Хөвсгөл нуурт мөсөн замын аюулгүй байдлыг хангах хяналтын постыг ажиллуулж, холбогдон гарах дээр дурдсан бүх зардлыг аймаг, орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх шаардлагатай. Мөн тухайн жилийн цаг уурын байдлаас хамаарч мөсний зузаан харилцан адилгүй байдгаас гадна дэлхийн дулаарлаас шалтгаалан мөсний зузаан жил ирэх тусам нимгэрч байгаатай холбогдуулан мөсөн замын тээврийг аюулгүй байдлын үүднээс багасгах, зөвхөн шаардлагатай тохиолдолд мөсөн замын тээвэрлэлтийг чиглэл, мөсний даацыг тогтоосны үндсэн дээр явуулах нь зүйтэй байна.

4. Усан болон мөсөн замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой 2013 онд 1, 2015 онд 4, 2016 онд 7, нийт 12 осол, зөрчил гарсан. Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд гарсан усны ахуйн ослын нөхцөл байдлын талаарх статистик мэдээг хавсаргав.

5. Усан замын тээврийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах, усан замын аялал жуулчлалыг дэмжих зорилгоор усан замын тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол бүхий зорчигч үйлчилгээний төв буудлыг Хөвсгөл нуурын эрэлт барьж байгуулах асуудлыг концессын гэрээгээр шийдвэрлүүлэхээр Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоол, түүний хавсралтаар батлагдсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 1 дэх хэсгийн 7⁴ дэх заалтад Засгийн газрын 2015 оны 133 дугаар тогтоолоор нэмэлт оруулж тусган дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

“Усан замын төв буудал”-ын ажлын даалгаврыг боловсруулан холбогдох яамдаас санал авч Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, барих газрыг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/16 дугаар, Хатгал тосгоны захирагчийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/71 дүгээр захирамжаар тус тус шийдвэрлүүлж, уг ажлыг концессын гэрээгээр гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтыг зарлуулахаар Үндэсний хөгжлийн газарт 2017 оны 12 дугаар сард албан бичгээр хүргүүлсэн. Үүнтэй холбогдуулан тус газраас ажлын хэсэг байгуулагдаж байгаа ба ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Зам, тээврийн яамны болон түүний харьяа Далайн захиргааны мэргэжилтнүүд оролцоо нэрсээ хүргүүлээд байна. Ажлын хэсэг ойрын үед хуралдахаар төлөвлөж байна.


Энэхүү арга хэмжээ хэрэгжсэнээр УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.117-д тусгагдсан “Дотоодын усан замын тээврийг хөгжүүлж, аюулгүй байдлыг хангасан нэгдсэн зогсоол, төв буудал барих бэлтгэл ажлыг хангах” гэсэн зорилт биелзэх боломжтой болохоос гадна усан замын тээврийн үйлчилгээний аюулгүй байдал хангагдаж, усан замын боомт болон хөгжих юм.

Усан замын тээврийн салбарт 2006 оноос өнөөг хүртэл 6,0 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг оруулсан бөгөөд цаашид жил бүр нэмэгдүүлж үндсэн чиглэл ба бусад эх үүсвэрт тусгаж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

6. Усан замын тээврийн аюулгүй байдлын талаар дараах эрх зүйн зохицуулалт, хууль эрх зүйн акт, дүрэм, журам үйлчилж байна. Үүнд:

- Усан замын тээврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 263 дугаар тушаалаар батлагдсан “Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм”;

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 263 дугаар тушаалаар батлагдсан "Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм";
- Зам, тээвэр, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд нарын хамтарсан 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 138/A208 дугаар тушаалаар батлагдсан "Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам";
- Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2005 оны 02 дугаар сарын 07-ны 23 дугаар тушаалаар батлагдсан "Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм";
- Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2005 оны 02 дугаар сарын 07-ны 23 дугаар тушаалаар батлагдсан "Усан замын зогсоол байгуулах, түүнийг ашиглах журам";
- Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 04 дүгээр сарын 05-ны 45 дугаар тушаалаар батлагдсан "Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам".

Хавсралт:  хуудастай.


Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.





МОНГОЛ ОРОНД ТОХИОЛДДОГ УСНЫ ОСЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР

2018 он




МОНГОЛ ОРОНД ТОХИОЛДДОГ УСНЫ ОСОЛ



Сүүлийн 5 жилийн судалгаагаар жилд дунджаар 100-112 хүн усны ослоор нас барж байгаагийн 30-35 хувь нь хүүхэд байна.



**УЛСЫН ХЭМЖЭЭНД 2011-2017 ОНД УСНЫ ОСЛЫН
ҮЛМААС НАС БАРСАН ХҮНИЙ ТОО**



2




УСАНД ОСОЛДОЖ НАС БАРСАН ХҮНИЙ ТОО

Шалтгаан	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бусад шалтгааны үлмэс Усанд осолдоож хүчийн тоо	88	104	119	100	90	134	112
Усан замын тээврийн хэрэгслийээс үүдэлтэй ослын шалтгаанаар амь насаа алдсан хүний тоо	0	0	1	0	4	7	0
Нийт	88	104	120	100	94	141	112


3



УСНЫ ОСЛЫГ АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР АВЧ ҮЗВЭЛ:




4



5




УСНЫ ОСОЛ ГАРЧ БАЙГАА ШАЛТГААН (2017)



6



УСНЫ ОСЛЫГ НАСНЫ АНГИЛЛААР АВЧ ҮЗВЭЛ



7